

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБА



Тээврийн цагдаагийн албаны товч танилцуулга

2018 оны 8 дугаар сард Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр Замын цагдаагийн албаны бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэстэй нэгтгэж, Тээврийн цагдаагийн алба болгон өргөжүүлснээр үйл ажиллагааг өмнө уламжилж арга хэлбэрээс өөрчилж, авто зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавихаас гадна, төмөр замын болон агаарын тээврийн аюулгүйн зурвас, хамгаалагдсан бүсэд гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, түүнээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг мөн хариуцуулсан нь тус албаны үйл ажиллагаанд түүхэн өөрчлөлт болсон.

Одоо тус алба 4 газар, 17 хэлтэс, 11 тасагтай, албаны бүтцийн нэгжийн 820 алба хаагчтай, харьяа нэгжийн буюу орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн Замын цагдаагийн тасаг, хэсэгт нийт 394 алба хаагч, Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг дэх замын цагдаагийн нэгжид 19 алба хаагч, улсын хэмжээнд нийт 1233 алба хаагчтай, энгийн 27 ажилтантай үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Тээврийн цагдаагийн албаны алба хаагчид нь байгалийн үзэгдэл, халуун хүйтэн болон өдөр шөнийн аль ч цагт ихэвчлэн гудамж замд үүрэг гүйцэтгэх шаардлага тулгардаг бөгөөд үүсэн байгуулагдсанаас хойшхи 80 гаруй жилийн хугацаанд дээрх хүнд бэрх ажлыг гүйцэтгэж, иргэдийн амь нас, эрүүл мэндийг гэмт халдлага, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваа хамт олон юм.

Бид дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлж, үйл ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг ашиглах бодлогыг баримтласнаар бэлэн бус торгуулийг нэвтрүүлсэн, цаашид зам тээврийн ослыг бүртгэж, шийдвэрлэх болон тээврийн хэрэгсэл зөөж шилжүүлэх үйл ажиллагааг мөн цахим хэлбэрт шилжүүлэхээр төлөвлөж байгаагаас гадна алба хаагчдын үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор олон улсын болон улсын чанартай авто зам дагуу 60 гаруй байнгын хяналтын цэг бариулах ажлыг зохион байгуулсан бөгөөд ирэх жилүүдэд албаны төв байр, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтсийн байрыг тус тус шинэчлэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.


Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.



Албаны түүхэн товчоо

Монгол Улсын хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхай, зам барилга, батлан хамгаалах болон бусад салбарт тээврийн хэрэгслийг өргөн ашиглах болсноор түүний хөдөлгөөнийг хянан зохицуулах, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих мэргэжлийн алба, нэгж байгуулах шаардлагын улмаас БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1936 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Улсын цагдан сэргийлэх газрын дэргэд “Улсын машин тэрэгний хэргийг байцаах хэлтэс”-ийг 2 офицер, 7 тусгай манаатайгаар байгуулж, уурын тэрэгний ашиглалт, тоо бүртгэл, жолооч нарын сахилга бат, үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хариуцуулсан нь одоогийн Тээврийн цагдаагийн алба байгуулагдах эхлэл тавигдсан байна.

Түүнчлэн Монгол, Зөвлөлтийн Засгийн газруудын хооронд 1936 онд байгуулсан хэлэлцээрийг үндэслэн 1938 онд Улаанбаатар-Налайхын хооронд анхны төмөр зам ашиглалтад орсонтой холбоотойгоор 1950 онд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын нэгдүгээр хэлтсийн харъяанд “Төмөр замын цагдан сэргийлэх групп”-ийг дарга 1, цагдаа 9 орон тоотойгоор баталж, төмөр замын хэвийн үйл ажиллагааг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих, Монгол-Оросын хамтарсан нийгэмлэгийн өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж ирсэн.



Албаны чиг үүрэг:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/159 дүгээр тушаалаар Тээврийн цагдаагийн албыг байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/208 дугаар тушаалаар Замын цагдаагийн албаны бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, Төмөр зам дахь цагдаагийн газар, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэстэй нэгтгэн, Тээврийн цагдаагийн албаны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан.

Тус алба нь бүтцийн /захиргааны удирдлагын, замын цагдаагийн, мөрдөн шалгах, төмөр зам болон иргэний агаарын тээвэр дэх/ нэгжийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төмөр замын аюултай бүсэд болон нисэхийн аюулгүйн бүсэд хяналт тавих, дээрх чиглэлээр гэмт хэрэг мөрдөн шалгах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах ажлыг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулах, бүтцийн болон харъяа нэгжийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн орчин, алба хаагчийн үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх болон хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж байна.



1. ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

Тус албаны Захиргааны удирдлагын газар нь харъяа нэгжийн үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, албаны үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, байгууллагын хэтийн болон ойрын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, дээд шатны байгууллага, албан тушаалтныг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна. Тус газрын бүтцэд “Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс”, “Урьдчилан сэргийлэх хэлтэс” багтдаг болно.

2. ЗАМЫН ЦАГДААГИЙН ГАЗАР

Замын цагдаагийн газар нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, үйлдэгдсэн зам тээврийн гэмт хэрэг, ослын дуудлага мэдээллийг бүртгэж, шалтгаан нөхцлийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан зохион байгуулах, олон улс, улс, орон нутгийн болон хурдны замуудад хяналт тавьж, зам тээврийн осолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, зам, замын байгууламж, хөдөлгөөн зохицуулах техник, хэрэгсэл болон хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

3. МӨРДӨН ШАЛГАХ ГАЗАР

Мөрдөн шалгах газар нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг мөрдөн шалгах, эзэн холбогдогчийг олж тогтоох, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тогтоож, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, төмөр зам, иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн нэгж, ажилтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгж, ажилтанд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэргийг мөрдөн шалгах чиглэлээр мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

4. ТӨМӨР ЗАМ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР

Төмөр зам дахь цагдаагийн газар нь төмөр замын аюултай бүс, төмөр замын өртөө, зөрлөг, зангилаа, зурвас газар, салбар нэгж, байгууллага болон ачаа тээш, зорчигчийн галт тэргэнд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, дээрх газарт гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорчигчдын амгалан тайван байдлыг хангах, авто замын хөдөлгөөнийг зохицуулах ажлыг хариуцан зохион байгуулах, төмөр замын аюултай бүсийн дэглэмд мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

5. ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВЭР ДЭХ ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэс нь иргэний нисэхийн хориотой, хамгаалагдсан болон нийтийн эзэмшлийн бүсэд мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, уг бүсэд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх, мөн дээрх бүс, газруудад мөрдөгдөх хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан зохион байгуулах, энэ чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, Иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, тэдэнд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна. /